



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/615

Мөрөн сум

Галт зэвсгийн тооллого зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Галт зэвсгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Хууль зүйн сайдын 2015 оны А/220 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Галт зэвсгийн тооллого явуулах зорилгоор “Зэвсэг-2023” арга хэмжээг аймгийн хэмжээнд 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. “Зэвсэг-2023” арга хэмжээг зохион байгуулах, удирдлага зохион байгуулалтаар хангахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Р.Машбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

С.Батхуяг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа)
Ц.Баатардорж (Хөвсгөл аймаг дахь Тагнуулын хэлтсийн дарга, хурандаа)
Б.Баасансүрэн (Хилийн 0257 дугаар ангийн захирагч, хурандаа)

Ч.Хуншагай (Аймгийн Татварын хэлтсийн дарга)

П.Мөнхжаргал (Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Сумын Засаг дарга нар

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Б.Алтанцог (Аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалан тасгийн дарга, цагдаагийн хошууч)

3. “Зэвсэг-2023” нэгдсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж тайлан мэдээг 2023 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн дотор нэгтгэн танилцуулахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж-2023

6712011423